



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 4/07


Жавхлант

**“Цагаан сар-Цагаан идээ 2026” үзэсгэлэн
худалдаа зохион байгуулах тухай**

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.2.5.2.1 дэх заалт, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.2.4.1.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, иргэд, байгалийн нөөцийн менежментийн нөхөрлөлүүд, хоршоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, олон нийтэд сурталчлан таниулах “Хүнсний хувьсгал” аяны хүрээнд хүн амыг чанартай, стандартын шаардлага хангасан сумын брэнд бүтээгдэхүүнийг бий болгох зорилтын хүрээнд “Цагаан сар-Цагаан идээ 2026” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсугай.
2. Үзэсгэлэн худалдаанд зарцуулагдах 2 000 000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын 2026 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д үүрэг болгосугай
3. “Цагаан сар-Цагаан идээ 2026” үзэсгэлэн худалдааны төсвийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн ахлагч нарт, хяналт тавьж хамтран ажиллахыг ХААТ-ийн мэргэжилтэн (Г.Номинцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ЦОЛМОНБАЯР



D:Zasag darga /zahiramj-2026/

**“ЦАГААН САР-ЦАГААН ИДЭЭ 2026” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	Өргөмжлөл	9	20 000	180 000
Нийт				180 000
Шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч				
№	Шагналын төрөл	Тоо хэмжээ	Мөнгөн дүн	
1	Шинэ, шинэлэг хүнсний бүтээгдэхүүн	1 ширхэг	200 000	
2	“Шилдэг сүүн бүтээгдэхүүн”	1 ширхэг	200 000	
3	“Шилдэг гурилан бүтээгдэхүүн”	1 ширхэг	200 000	
4	“Шилдэг гар урлал”	1 ширхэг	200 000	
5	“Шилдэг байгалийн шимт бүтээгдэхүүн”	1 ширхэг	200 000	
6	Тусгай шагнал	3 ширхэг	480 000	
7	Шилдэг нөхөрлөл	1 ширхэг	250 000	
Нийт		9 ширхэг	1 730 000	
Нийт зардал				
“ЦАГААН САР-ЦАГААН ИДЭЭ 2026” Аймгийн нэгдсэн үзэсгэлэн худалдаанд оролцох зардлын төсөв				
№	Зардлын төрөл	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	Ай92	32.49литр	2770	90 000
Нийт дүн				2 000 000